

## **БАТЛАВ:**

# **САНХҮҮГИЙН ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик шаардлага байна. Үүнд:

#### **1.1. Хууль зүйн шаардлага**

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1.3.1-т “Санхүү, даатгал хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилнэ.”, 3.1.3.2-т “Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд таатай нөхцөлөөр санал болгох санхүүгийн бүтээгдэхүүнийг дэмжинэ.” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого”-ын 4 дүгээр бүлгийн 4.3 дахь зорилгод “Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ” гэж тусгасан бөгөөд I үе шат (2021-2030 он)-нд “Бичил санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулан эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулж, үйл ажиллагааны хүрээг тэлсэн байна.”, II үе шат (2031-2040 он)-нд “Бичил санхүүгийн зах зээлийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн санхүүгийн салбарт эзлэх хэмжээг нэмэгдүүлсэн байна.”, III үе шат (2041-2050 он)-нд “Технологийн дэвшилд суурилсан бичил санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.” гэж тус тус тусгасан. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.3.29-д “Хоршоодын гишүүн төвтэй зохицуулалтын орчин бий болгох, бичил банкны эрх зүйн орчныг нэвтрүүлнэ.”, 4.3.39-д “Бичил санхүүгийн зах зээлд ашиглагдах технологийн шийдлүүдийг дэлхийн хөгжингүй орнуудтай ижил түвшинд хүргэнэ.” гэж тусгасан.

Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан 2023 оны А-34/106/43/А/20 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Санхүүгийн салбарын бодлогын арга хэмжээний төлөвлөгөө /2023-2024/”-ийн 5.2.2.1-д “Салбарын эрх зүйн орчныг олон улсын стандартад нийцүүлнэ.”, 5.2.3.1-д “Хадгаламж, зээлийн хоршоодын дэд бүтцийг олон улсын түвшинд нийцсэн байдлаар хөгжүүлнэ.” гэж тус тус заасан.

#### **1.2. Практик шаардлага**

2024 оны байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр 178 ХЗХ үйл ажиллагаа явуулж, салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар өссөн үзүүлэлтэй байна. Салбарын нийт хөрөнгө дотоодын нийт бүтээгдэхүүний 0.5 хувь, гол үзүүлэлт болох хадгаламж болон зээлийн дүн банкны зах зээлийн мөн үзүүлэлтийн 0.7 орчим хувьтай тэнцэж байна. Нийт гишүүдийн тоо 2024 оны байдлаар 75,252 хүрсэн нь эдийн засгийн идэвхтэй хүн амын 5.2 хувийг бүрдүүлж, Ази тивийн дундаж (5.92%)-тай ойролцоо, дэлхийн хэмжээний дундаж үзүүлэлт (12.69)-ээс 6.8 пунктээр доогуур түвшинд байна. Монгол Улсын 18-64 насны 26 хүн тутмын нэг нь хадгаламж, зээлийн хоршоонд гишүүн, 70 хүн тутмын нэг нь зээл

авсан, 44 хүн тутмын нэг нь хадгаламж төвлөрүүлсэн байна. Хэдийгээр санхүүгийн зах зээлд эзлэх хэмжээ харьцангуй бага ч тогтвортой, зохистой өсөлтийг үзүүлж буй зах зээл юм.

Улсын Их Хурлаас 2011 онд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг баталсан ба 2015 онд Зөрчлийн тухай хууль баталсантай холбоотой, 2022 онд Улсын бүртгэлийн ерөнхий хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотой, 2023 онд Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай холбоотой, 2024 онд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотой хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор 4 удаа нэмэлт, өөрчлөлт оруулснаас өөрөөр шинэчлэл хийгээгүй. Тасралтгүй хөгжиж байгаа зах зээлийн чиг хандлагад тохирсон зохицуулалтыг бий болгоход хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гишүүдийн санхүүгийн хэрэгцээнээс гадна нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг бүрэн хангаж чадахуйц хоршоодыг хөгжүүлж олон улсын чиг хандлагад нийцүүлэх дараах практик шаардлага тулгарч байна. Үүнд:

1. Хадгаламж, зээлийн хоршооны салбар дахь 1 шатлалт хамгаалалтын тогтолцоог өөрчилж, хамгаалалтын 3 давхарга бүхий тогтолцоонд шилжүүлж, нэгдсэн дэд бүтцийг бий болгох:

1.1. Зах зээлийн найдвартай байдал, хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалахын тулд дэлхийн улс орнууд хамгаалалтын 2-3 давхарга бүхий тогтолцоог бий болгон ирсэн. Үүнд, нэгдүгээрт, хоршоодын цэвэр орлогоос байгуулдаг нөөцийн сан, хоёрдугаарт, үйл ажиллагааны түр хугацааны хүндрэлд орсон, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар алдагдсан хоршоодод мэргэжил арга зүйн болон санхүүгийн туслалцаа үзүүлж, үйл ажиллагааг сэргээхэд чиглэдэг тогтворжуулалтын сан, гуравдугаарт, хадгаламжийн даатгал бөгөөд хоршоо дампуурсан тохиолдолд даатгагдсан хадгаламжийг хадгаламж эзэмшигчид нөхөн олгодог. Манай орны хувьд хадгаламж, зээлийн хоршоод хамгаалалтын нэгдүгээр давхаргын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд олон давхаргат хамгаалалтын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлснээр салбарын нэгдсэн бодлого, удирдлагын дор төрд үүсэх дарамтгүйгээр энэхүү салбарыг тогтвортой хөгжүүлж, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах замаар зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх боломжтой юм.

1.2. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт “Хадгаламж зээлийн хоршоодын гишүүдийн хадгаламж даатгалтай байна. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн хадгаламжийн даатгалтай холбогдсон харилцааг хадгаламжийн даатгалын хуулиар зохицуулна.” гэж заасан ч Монгол Улсын хадгаламжийн даатгалын систем нь зөвхөн банкин дахь хадгаламжид хамаарч, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд хоршооны хадгаламж эзэмшигч гишүүдийн мөнгөн хадгаламжийг хамгаалах зохицуулалтгүйгээс тодорхойгүй байдал үүссэн. Хадгаламжийн даатгалд хадгаламж татдаг бүхий л санхүүгийн байгууллагуудыг хамруулах олон улсын сүүлийн үеийн чиг хандлагад нийцүүлэн хоршооны гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулах зохицуулалтыг холбогдох хуульд тусгах шаардлагатай байна.

1.3. Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгийг хамгаалах ач холбогдлыг харгалзан салбарын хамгаалалтын хоёрдугаар давхарга болох тогтворжуулалтын сангийн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Холбоо нь дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гишүүн хадгаламж, зээлийн хоршоодын санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор тогтворжилтын үйлчилгээ үзүүлэх”-ийг зөвшөөрч, 54 дүгээр зүйлийн 54.1-д “Холбоо нь тогтворжилтын сан байгуулж, санхүүгийн тогтворжилтын үйлчилгээ үзүүлэхэд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:” гэж заасан боловч Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо нь

төрийн бус байгууллага тул тогтворжуулалтын сангийн буюу санхүүгийн төвлөрсөн үйл ажиллагаа эрхлэх боломжгүйгээс хэрэгжээгүй. Иймд тогтворжуулалтын санг удирдах дундын санхүүгийн байгууллагыг байгуулж, энэхүү дундын санхүүгийн байгууллага нь тусгай зөвшөөрөл бүхий хоршоодын заавал гишүүнчлэлтэй байх бөгөөд тогтворжуулалтын санг удирдахаас гадна гишүүддээ санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ, дэмжлэг үзүүлж ажиллана.

2. Монгол Улсад хадгаламж, зээлийн хоршоод 1996 оноос эхлэн байгуулагдаж, түүхийн тодорхой үе шатыг давж өнөөдрийг хүрсэн. Хадгаламж, зээлийн хоршооны 2005-2006 оны хямрал хяналт зохицуулалт хангалтгүй, иргэдийн хоршооны тухай мэдлэг муу байснаас зарим хоршоодын үйл ажиллагаа ашгийн төлөө бус байх, нийгмийн чиг баримжаатай байх сонгодог утгаас гажуудаж, жижиг банк, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны хэлбэрт шилжиж, анх үүсгэн байгуулсан бүлэг этгээдүүдийн гарт хоршооны удирдлага төвлөрснөөс үүдэж олон гишүүн, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хохироосон. Энэ үйл явдал дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн хоршооллын хөдөлгөөний нэр хүндийг Монголд унагасан хор уршгийг авч ирсэн. Хоршооны хөгжлөөр тэргүүлж буй Канад улсын хоршооны гишүүдийн тоо эдийн засгийн идэвхтэй хүн амын тоотой харьцуулахад 49 хувь, АНУ-д 44 хувь, БНСУ-д 23 хувь байхад энэ үзүүлэлт Монголд 2 хувь байгаа нь дээрх үйл явдалтай холбоотой.

Үүссэн нөхцөл байдлыг засаж салбарыг хянах зохицуулах байгууллагатай болгож, УИХ-аас 2011 онд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг баталснаар салбар цэгцэрсэн боловч салбарын нэршлийг өөрчлөх (ребрендинг) маркетингийн алхам нь олон нийтийн дундах хоршооны талаарх төсөөллийг өөрчлөх, салбарын хөгжлийг эрчимжүүлэх боломжтой. Олон улсын туршлагаас үзэхэд хадгаламж, зээлийн хоршоодын нэгдсэн нэр байхгүй байна. Тухайлбал, зээлийн холбоо (credit union), ард түмний касс (caisses/cajas populares), хоршооллын банк (cooperatives bank), харилцан туслалцааны банк (mutual banks), хөршийн банк (neighbors bank), хадгаламж, зээлийн хоршоо (savings and credit cooperatives), SACCO зэрэг нэр томъёог улс орнууд ашиглаж ирсэн бөгөөд Дэлхийн банк эдгээр нэршлийг нэгтгэн санхүүгийн хоршоо (financial cooperatives) гэж томъёолсон байдаг.

Иргэний хуулийн 33 дугаар зүйлд зааснаар ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулах зохицуулалттай тул манай нөхцөлд хоршооны хэлбэрээ авч үлдэж, хадгаламж, зээл болон санхүүгийн бусад үйлчилгээг үзүүлэх санаагаар “санхүүгийн хоршоо” гэсэн өргөн хүрээний нэр томъёогоор өөрчлөхөөр хуулийн төслийг боловсруулна. Ребрендинг хийснээр хадгаламж, зээлийн хоршооны талаарх иргэдийн муу төсөөлөл арилж, олон улсад хөгжүүлсэн утгаар нь нутагшуулбал олон нийтийн итгэлийг төрүүлэх боломжтой болно.

3. Хоршооны гишүүддээ үзүүлж болох үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлнэ. Тухайлбал, санхүүгийн бусад ажил, үйлчилгээнд хамаарах даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа нь 1 даатгалын компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамаардаг тул холбогдох хуульд өөрчлөлт оруулах замаар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа болгон өргөжүүлж, гишүүдэд сонголт хийх боломжийг олгоно. Төсөл хөтөлбөр дамжуулан хэрэгжүүлэх, санхүүгийн түрээс, факторинг зэрэг санхүүгийн үйлчилгээнүүд, шаардлагатай тохиолдолд Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр Үндэсний төлбөрийн системн тухай хуульд заасан үйл ажиллагааг эрхлэхийг зөвшөөрөх;

4. Хадгаламж, зээлийн хоршоо нь ашгийн төлөө бус хуулийн этгээд боловч үйл ажиллагааны үр дүнд бий болсон орлогод аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулж байх тул аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх замаар ашгийн төлөө бус хуулийн этгээдэд дэмжлэг

үзүүлэх хэрэгцээтэй байна. Татвараас чөлөөлснөөр зээлийн хүү зэрэг гишүүдэд зориулсан үйл ажиллагааны өртөг буурахад дөхөм болно.

5. Хоршооны эрх барих дээд байгууллага болох бүх гишүүдийн хурлын зохион байгуулалтыг сайжруулах, цаг үеийн нөхцөлд нийцүүлэн үйл ажиллагаа, бүх гишүүдийн хурлыг цахим болон бусад хэлбэрээр явуулах боломжийг нээх;

6. Хадгаламж, зээлийн хоршооны санхүүгийн тайлагналыг сайжруулж, санхүүгийн тайланд аудит хийх байгууллагыг хяналтын зөвлөл сонгож байх, тухайн хоршоо төлбөрийн чадваргүй болсон, эсхүл аливаа үйл ажиллагаа нь хууль тогтоомж зөрчсөн байдал илэрвэл тайланг хянасан аудитын байгууллага энэ талаарх мэдээллийг Хороонд шуурхай ирүүлж байх, шинээр байгуулагдсан хоршоодын санхүүгийн тайланг хараат бус аудитын байгууллагаас бусад этгээд хянах боломжийг нээх;

7. Хоршооны гишүүнчлэлийн нөхцөлийг оновчтой болгож, гишүүнээр элсэх, гарах, идэвхгүй гишүүнд тооцох, хасах харилцааг нарийвчилж зохицуулах;

8. Хадгаламж, зээлийн хоршооны засаглалыг сайжруулах, сонгуульт гишүүдэд тавих шаардлагыг шинэчлэх, үйл ажиллагаа тасралтгүй явуулах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн санхүүгийн байгууллагын түвшинд хүргэхэд шаардлагатай зохицуулалтуудыг тусгах;

9. Гишүүдийн эдийн засгийн хэрэгцээнээс гадна нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг бүрэн хангаж чадахуйц, хөдөө аж ахуйн орны мал аж ахуйн онцлогт тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээтэй санхүүгийн хоршоог хөгжүүлэх боломжийг нээх;

10. Хоршоо нь гишүүн төвтэй, гишүүддээ санхүүгийн боловсрол олгодог байгууллага болохыг тодруулна. Төв газраас алслагдсан орон нутгийн иргэдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, сүүдрийн эдийн засгийг бууруулж, санхүүгийн зөв дадал хэвшлийг гишүүддээ суулгаснаар тэдний зээлийн түүх сайжирч, хариуцлагатай болгоно;

11. Хоршооны үйл ажиллагаа доголдоход Хорооноос авах арга хэмжээг тодорхой болгож, тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон хоршооны төлбөр тооцоог дуусгах арга хэмжээг оруулах зэрэг.

### **Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийн зорилго нь хадгаламж, зээлийн хоршооны салбарын эрх зүйн орчныг хөгжлийн чиг хандлага болон олон улсын стандартад нийцүүлэх, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг тодорхойлоход оршино.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.4-д заасныг үндэслэн хуулийн нэр томъёог оновчтой болгох, зарим зүйл заалтыг найруулах, хүчингүй болгох, шинээр зүйл, заалт нэмэх зэргээр хуулийн нийт заалтын тавиас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай, мөн тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч байх тул төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна. Хуулийн төсөл нь 13 бүлэгтэй байх бөгөөд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, зарчим, нэр томъёоны тайлбар, Хоёрдугаар бүлэгт санхүүгийн хоршооны эрхлэх үйл ажиллагаа, хориглох зүйл, Гуравдугаар бүлэгт санхүүгийн хоршооны үйл ажиллагааг зохицуулах байгууллагын талаар, Дөрөвдүгээр бүлэгт тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт, Тавдугаар бүлэгт гишүүнтэй холбоотой зохицуулалт, гишүүний эрх, үүрэг, хариуцлага, Зургадугаар бүлэгт санхүүгийн

хоршооны зохион байгуулалт, удирдлага, дотоод хяналт зэрэг зохицуулалт, Долдугаар бүлэгт санхүүгийн хоршооны гишүүний хувь хөрөнгө, санхүүгийн тайлагнал, аудит, татварын талаарх зохицуулалт, Наймдугаар бүлэгт санхүүгийн хоршоодын дундын санхүүгийн байгууллага болон тогтворжуулалтын сангийн зохицуулалт, Есдүгээр бүлэгт хадгаламж хамгааллын тогтолцоо, хадгаламжийн даатгалын зохицуулалт, Аравдугаар бүлэгт санхүүгийн хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгах тухай зохицуулалт, Арваннэгдүгээр бүлэгт, санхүүгийн хоршооны үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалт, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, Арванхоёрдугаар бүлэгт албадагын арга хэмжээ, нөхцөлт удирдлага, бүрэн эрхт төлөөлөгч, өөрчлөн байгуулах, албадан татан буулгах, Арвангуравдугаар бүлэгт хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага болон хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаарх бусад зохицуулалтыг тусгахаар хуулийн төслийг боловсруулна.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж баталснаар дараах үр дүнд хүрнэ гэж тооцож байна. Үүнд:

1. Санхүүгийн хоршооны салбарын нэгдсэн дэд бүтэц буюу тогтворжуулалтын сан, хадгаламжийн даатгал зэрэг хамгаалалтын олон давхаргат тогтолцоог олон улсын түвшинд нийцсэн байдлаар үе шаттайгаар нэвтрүүлснээр салбарын нэгдсэн бодлого, удирдлагын дор төрд үүсэх дарамтгүйгээр санхүүгийн хоршооны салбарыг тогтвортой хөгжүүлнэ.

2. Санхүүгийн хоршооны засаглал, санхүүгийн тайлагнал, технологийн дэвшил, цахим шилжилттэй холбоотой өөрчлөлтүүдийг тусгаж, ашгийн төлөө бус хуулийн этгээд байх нарийвчилсан зохицуулалтууд хийгдсэнээр санхүүгийн хоршооны зах зээлийн тогтвортой байдлыг хангах, зах зээлийн цаашдын өсөлтийн нөхцөлийг бүрдүүлэх, гишүүн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах механизм боловсронгуй болохоос гадна зээлийн хүү буурах, бичил банкны эрх зүйн орчин бүрдүүлэх ач холбогдолтой.

3. Санхүүгийн хоршоогоор дамжуулан иргэдэд санхүүгийн боловсрол олгож, зөв дадал хэвшил суулгаснаар төв газраас алслагдсан орон нутгийн иргэдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, сүүдрийн эдийн засаг, “мөнгө хүүлэгчид”-тэй тэмцэхэд тусална.

4. Хоршооноос үйлчилгээ авах шаардлагатай, боломжтой бүхий л хүнд хүрч үйлчлэхийг зорьдог гишүүддээ ойр байгууллага тул хоршооноос үүссэн “ашиг” тухайн орон нутагт, гишүүддээ үлдэж, орон нутгийг хөгжүүлнэ.

5. Санхүүгийн хоршоо нь гишүүдийн хэрэгцээг хангах зорилгоор бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, орон нутгийн хөгжил, ногоон санхүүг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлснээр ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, байгаль орчныг хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулна.

6. Хууль батлагдсанаар Хорооноос санхүүгийн хоршооны үйл ажиллагаанд тавьж буй хяналт шалгалтын үр нөлөө, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулж, зохицуулалтын эрх зүйн орчин олон улсын жишигт нийцэж, санхүүгийн салбарт бий болж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, салбарт учирч болзошгүй эрсдэл хүндрэлийг урьдчилан тооцох, бууруулах боломжийг бий болгож, салбарын хөгжлийг дэмжих таатай орчин бий болно. Мөн санхүүгийн хоршооны үйл ажиллагааны цар хүрээ өргөжих,

санхүүгийн шинэ үйлчилгээ бий болох, санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэх, гишүүн төвтэй зохицуулалтын орчин бүрдэнэ.

Санхүүгийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, салбарын цаашдын хөгжлийг дэмжсэн чухал арга хэмжээ болно.

**Дөрөв. Хуулийн төсөл Үндсэн хууль, Монгол Улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомж байгаа эсэх талаарх санал**

Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн байна.

Мөн энэхүү хуулийн төсөлтэй хамт Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.